

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны
..... тоот албан бичгийн зургаадугаар хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2024.12.02

Улаанбаатар хот

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (Сая төгрөг)	2024 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилт (хувиар)
5	4.1.1. Төрийн байгууллагын мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг халж, иргэд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай авдаг болох зорилтыг бүрэн хэрэгжүүлж, "Нэг иргэн-Нэг бүртгэл" арга хэмжээг үргэлжлүүлэн, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн стандартад оруулна.	6. УБЕГ, орон нутаг дахь улсын бүртгэлийн газар, хэлтсийн архив, үйлчилгээний байр, тохижилт, техник хэрэгсэл, аюулгүй ажиллагаа, хадгалалт хамгаалалтыг сайжруулна.	2020 - 2024	478,6	4 аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн архив үйлчилгээний барилгыг ашиглалтад оруулах, техник тоног төхөөрөмжөөр хангасан байна.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэхээр УБЕГ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Сонгинохайрхан дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн барилгыг ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулах, Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн барилгын засварын ажлыг хийж, албан хаагчдын ажиллах орчныг сайжруулах арга хэмжээнүүдийг тус тус тусгасан. Сонгинохайрхан дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн барилга угсралтын ажлыг барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо УБЕГ-ын даргын 2024 оны А/39 тоот тушаалаар байгуулагдсан. Барилга угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд барилгын суурьт тулсан айлыг нүүлгэн газрыг Улсын бүртгэлийн хэлтсийн нэр дээр шилжүүлсэн тухай Засаг даргын захирамж гарсан. Ажлын даалгаврыг батлуулсан бөгөөд барилгын зургийн холболт төсвийг бэлдэн Барилгын хөгжлийн төвд хүргүүлэх, барилгын техникийн нөхцөл авах, гэрээ байгуулах ажлууд тус тус хийгдэж байна. Тендер шалгаруулалтыг бэлтгэл ажил хангагдаад байна. 2024 оны төсөлд 5,8 тэрбум төгрөг тусгаж, 2,4 тэрбум төгрөгийг батлуулсан. Барилга угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд барилгын суурьт тулсан айлыг нүүлгэн газрыг	70

					шилжүүлэн Нийслэлийн Засаг даргын 2024.05.03-ны өдрийн А/498 дугаар захирамжаар газар эзэмших эрхийн 0000284276 дугаартай гэрчилгээг авсан. Мөн BBSMO ХХК-тай 2024.09.06-ны өдөр 2024/64 тоот гэрээг байгуулан хамтран ажиллан, Барилгын хөгжлийн төвийн барилга байгууламжийн дүгнэлт 2024.11.18-ны өдөр баталгаажиж, нийт төсөвт өртөг 6,4 тэрбум төгрөгөөр баталсан. Барилга угсралтын ажлыг барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн нээлтийг хуулийн хугацаагаар 2024.12.13-ны өдөр нээж дүгнэлт, мэдэгдлийг хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн байрны их засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны А/03 тоот тушаалаар байгуулагдсан. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулж гүйцэтгэгчээр шалгарсан “Өгөөмөр уул” ХХК-тай ХЗДХЯ/20240101023, 24 тоот гэрээ байгуулж, 2024.08.01-ний өдөр улсын комисс хүлээн авч, нүүлгэлтийн ажлыг зохион байгуулан 2024.08.05-ны өдрөөс эхлэн Улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд үзүүлж эхлээд байна.	
6	7. Иргэний улсын бүртгэлийн дугаар болон тоон гарын үсгийг улсын болон төрөлжсөн бүртгэлийн үйлчилгээнд бүрэн нэвтрүүлэн, бүртгэлжүүлнэ.	2020 - 2024	5791.0	Иргэний улсын бүртгэлийн дугаарыг хэрэглээнд нэвтрүүлэх, улсын бүртгэлийн үйлчилгээний тоон гарын үсгийн ашиглалтыг 20	Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн нэмэлт, өөрчлөлт 2022 онд батлагдсанаар хувь хүний мэдээллийн нууцлалыг хадгалах, иргэний регистрийн дугаар, байнга оршин суугаа газрын хаягийн мэдээллийг иргэний үнэмлэхийн санах ойд байршуулж, иргэний талаар ямар нэг мэдээлэл агуулаагүй, дахин давтагдахгүй иргэний бүртгэлийн дугаарыг ил харагдах бичилт хийх, төрийн байгууллагын үйлчилгээг авахад иргэний бүртгэлийн дугаарыг ашиглах боломжийг бүрдүүлсэн.	100

					<p>хувьд хүргэсэн байна.</p> <p>“Монгол Улсын иргэний үнэмлэхийн тодорхойлолт, загварыг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 374 дүгээр тогтоолоор батлуулж, иргэний бүртгэлийн 12 оронтой дугаарыг регистрийн дугаарын оронд ил харагдах байдлаар оруулж шинэчилсэн загварын иргэний үнэмлэхэд бичилт хийх ажлыг 2022.12.13-ны өдрөөс эхлүүлсэн бөгөөд 2024.11.25-ны өдрийн байдлаар иргэнд 494,100 иргэний үнэмлэхийг олгосон байна.</p> <p>Төрийн мэдээлэл солилцооны (ХУР) системээр дамжуулан төрийн болон бусад байгууллага иргэний улсын бүртгэлийн дугаараар мэдээлэл авах боломжтой болсон. Монгол Улсад төрсөн болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар харьяат болсон иргэний улсын бүртгэлийг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд хөтөлж, тухай бүр мэдээллийн сангаас иргэний бүртгэлийн дугаар шууд олгогдож, иргэний харьяаллыг сэргээн тогтоосны бүртгэл хөтөлсөн тохиолдолд тухайн иргэний бүртгэлийн дугаарыг мэдээллийн сангаас сэргээж, ашиглах боломжтой болсон.</p> <p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу иргэнд иргэний бүртгэлийн дугаарыг ашиглан цахим шуудангийн хаяг нээн, Сонгуулийн тухай хуулиудын хэрэгжилтийг хангаж, сонгогчдын нэрийн жагсаалт болон сонгогчийн ирц бүртгэлийн программд сонгогчийн иргэний бүртгэлийн дугаарыг оруулахаар хөгжүүлэлт хийсэн.</p> <p>Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2022.05.01-ний өдрөөс Монгол Улсын 16 ба түүнээс дээш насны иргэддээ тоон гарын үсгийг 21 аймаг, 9 дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтэс,</p>
--	--	--	--	--	---

						<p>Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдээр тоон гарын үсгийг олгож эхэлсэн бөгөөд иргэний үнэмлэхийн санах ой буюу чипэнд, КИОСК машинаар, мөн гар утасны аппликэйшнаар олгож байна.</p> <p>Монгол Улсын 45 ДТГ-аар дамжуулан тус улсад ажиллаж, амьдарч байгаа иргэдэд тоон гарын үсэг олгох ажлыг эхлүүлсэн бөгөөд 2024.11.25-ны өдрийн байдлаар АНУ-д 82, Канад улсад 3, БНСУ-д 128, ОХУ-д 4, Австрали улсад 2, Австри улсад 5, Бельги улсад 1, Болгар улсад 1, ХБНГУ-1, Кувейт улсад 2, Турк улсад 2, Польш улсад 1, Швед улсад 2, Швейцарь улсад 2, Казакстан улсад 1, БНХАУ-1, Япон 2 нийт хүсэлт гаргасан 244 иргэнд олгосон байна. Иргэдэд тоон гарын үсэг олгосноор төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia.mn/-д нэвтэрч, төрийн байгууллагын бусад үйлчилгээг цахим хэлбэрээр авах боломжийг бүрдүүлсэн. 2024.11.25-ны өдрийн байдлаар 1,439,716 иргэнд тоон гарын үсэг олгосон.</p>	
7		8. Иргэний үнэмлэхийн үйлдвэрийг өргөтгөн гадаад паспортын бэлдэцэд бичилт хийх үйлдвэрийн бүтцийг УБЕГ-т байгуулж, үндэсний цахим гадаад паспортыг хэрэглээнд нэвтрүүлнэ.	2020 - 2024	3471,7	Үндэсний цахим гадаад паспортын хэрэглээг 25 хувиар нэмэгдүүлсэн байна.	<p>Монгол Улсын Засгийн газрын 2020.03.11-ний өдрийн “Гадаад паспорт хэвлэх талаар авах арга хэмжээний тухай” 92 дугаар тогтоол, Монгол Улсын Их хурлын 2020.12.09-ний өдрийн 203 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 4.1.1 дэх зорилтын 8 дугаар арга хэмжээ, Монгол Улсын Засгийн газрын 2022.04.13-ны өдрийн “Үндэсний гадаад паспортын загвар, тодорхойлолт батлах тухай” н/155 дугаар тогтоолоор батлагдсан загвар, тодорхойлолтын хэрэгжилтийг тус тус ханган Хэвлэх үйлдвэрийн үйл ажиллагааг 2022.10.01-ний өдрөөс эхлүүлсэн. 2022.10.01-ний өдрөөс 2024.11.25-ны өдрийн байдлаар нийт 986,151 иргэн гадаад паспорт авах хүсэлт</p>	100

					<p>гаргасан бөгөөд үүнээс энгийн гадаад паспорт 327,199, цахим гадаад паспорт 658,952 иргэний хүсэлтийг тус тус хүлээн авч гадаад паспортын бүртгэл хөтлөн, паспортыг хэвлүүлж, холбогдох нэгжээр дамжуулан иргэнд олгосон.</p> <p>Иргэний үнэмлэхийн машин, дагалдах тоног төхөөрөмж, систем худалдан авах тендерийн урилгыг 2024.01.18-ны өдөр www.tender.gov.mn, www.burtgel.gov.mn сайтад тус тус байршуулж, “Смарт карт” ХХК-ийн тендер шаардлагад нийцсэн тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28.1.1-д заасны дагуу гэрээ байгуулах эрх олгох албан мэдэгдэл хүргүүлсэн боловч хуулийн хугацаанд Сангийн яамнаас ирүүлсэн “Гомдол хянасан тухай” 2024.03.12-ны өдрийн 03/1433 тоот албан бичигт дурдсаны дагуу “Тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийж, мөн хуулийн 59.10.2 дахь заалтын дагуу мэдэгдэж байна./ гэж заасныг үндэслэн тухайн багцын тендерийг дахин үнэлсэн.</p> <p>Үнэлгээгээр сайн тендерээр шалгарсан “Смарт карт” ХХК-тай 2024/34 тоот гэрээ байгуулав. Гэрээнд тусгагдсан тоног төхөөрөмж, программ хангамжийг УБЕГ-ын даргын 2024 оны А/57 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2024.04.19-ний өдрийн 01 дугаартай актаар хүлээн авсан. Иргэний үнэмлэхэд бичилт хийх тоног төхөөрөмж, модуль хоорондын холболтын ажлыг 2024.04.22-ноос эхлүүлж, 2024.04.26-ны өдөр туршилтын ажлыг хийж, 21 аймаг 35,442, нийслэлийн 9 дүүрэг, үйлчилгээний нэгдсэн төв, нэг цэгийн үйлчилгээ 188,053, e-mongolia 32,914, ДТГ-аар дамжин ирсэн 5,951 нийт 262,360 иргэний цахим үнэмлэх хэвлэн, хүргүүлсэн.Гэрээний гүйцэтгэл 100 хувь.</p>	
--	--	--	--	--	--	--

8		10. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газартай хамтран хаягийн нэгдсэн мэдээллийн сантай болно.	2020 - 2024	-	Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ солих ажлын 100 хувийг гүйцэтгэсэн байна.	<p>Барилга, хот байгуулалтын сайд, Цахим хөгжил, УБЕГ, ГЗБГЗЗГ-ын даргын хамтарсан 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/118, А/462 дугаар тушаалаар байгуулагдсан Хаягийн болон газар, үл хөдлөх эд хөрөнгийн дундын мэдээллийн сан байгуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга нарын хамтарсан А/275, А/152 дугаартай тушаалаар өөрчлөлт орсон бөгөөд 2024.10.24-ний өдөр шинэ бүрэлдэхүүнээрээ хурлыг зохион байгуулж 100%-ийн ирцтэй оролцсон. Тус хурлаар дараах 2 асуудлыг хэлэлцсэн. Үүнд:</p> <p>1. Хоёр байгууллага хоорондоо солилцсон мэдээллийн талаар:</p> <ul style="list-style-type: none"> - УБЕГ-аас ГЗБГЗЗЕГ-т нийлүүлсэн сервисийн мэдээлэл: - Газар өмчлөлийн түүхчилсэн мэдээллийг харах сервис (2024 онд); - Хаягийн бүтцийн мэдээллийг багана тус бүрээр тайлбарын хамт хүргүүлсэн (2023 онд хүргүүлсэн. Баг хорооны код зөрсөн байсныг ГЗБГЗЗГ-аас засч хаягийг дахин тулгахаар тохирсон байсан); - Барилгатай холбоотой баримт бичгийг цахимаар солилцох хүрээнд үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой нийт 13 нотлох баримтын жагсаалт, хаягийн мэдээлэл, газрын мэдээлэл болон өмчлөгчийн мэдээллийн талбарын жагсаалтыг тус тус гаргаж хүргүүлсэн (2023 онд); - ГЗБГЗЗЕГ-аас УБЕГ-т нийлүүлэх сервисийн мэдээлэл: - Газар эзэмших ашиглах эрхийн бүртгэлийн түүхчилсэн мэдээллийг харах сервис (одоо зөвхөн анхны бүртгэл л харагдаж байгаа бөгөөд нэмэлт өөрчлөлт болон 	70
---	--	--	-------------	---	---	--	----

					<p><i>барьцааны бүртгэл зэрэг бусад бүртгэлийн мэдээлэл харагдахгүй байгаа)</i></p> <p>- Хуучин нэгж талбарын дугаарын хаягийн жагсаалт; 2.Ажлыг эрчимчүүлэх талаар цаашид хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулах гэх мэт.</p> <p>Хаягийн санг нэгтэх зорилгоор улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан дахь кадастрын дугааргүй бүртгэлийг нөхөж оруулах ажлыг эхлүүлсэн бөгөөд 2024.11.25-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд нийт 128,783 нэгж талбарын дугаар буюу нийт нөхөж оруулах шаардлагатай бүртгэлийн 62.7%-ийг нөхөж оруулаад байна. Эд хөрөнгийн хаяг өөрчлөгдөх бүртгэл улсын хэмжээнд тайлант хугацаанд 603 бүртгэл хийгдсэн байх бөгөөд 2024 онд өссөн дүнгээр 7,666 хаяг өөрчлөгдсөн бүртгэл хийгдсэн байна.</p> <p>Мөн Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 60 дугаар захирамжаар "Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай" Засгийн газрын 2022 оны 180 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх, салбар хоорондын холбогдох үйл ажиллагааг уялдуулах ажлыг зохион байгуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд нарийн бичгийн даргаар УБЕГ-ын дарга ажиллаж байна. Тус ажлын хэсгийн анхдугаар хурал 2024.11.22-ны өдөр зохион байгуулагдаж, УБЕГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч У.Болдхүү болон Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын дарга Б.Ариунболд нар оролцож "Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг Улсын бүртгэлийн ерөнхий газартай холболт хийж дундын мэдээллийн санг байгуулах ажлын талаарх танилцуулга"-ыг хийсэн.</p>
--	--	--	--	--	---

9		11. Мэдээлэл солилцох болон дундын мэдээллийн сангийн хэрэглээг нэмэгдүүлэх замаар Улсын бүртгэлийн мэдээллийг төрөлжсөн бүртгэлд ашиглана.	2020 - 2024	-	Улсын бүртгэлийн мэдээлэл солилцоо болон дундын мэдээллийн сангийн хэрэглээ нэмэгдсэн байна.	<p>Мэдээлэл солилцох болон дундын мэдээллийн сангийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд газар эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн дугаар олгох болон Монголын нотариатчидын танхимын гишүүн нотариатч нартай мэдээлэл солилцон ажиллаж байна.</p> <p>Газар эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн дугаарыг дундын мэдээллийн сангаар дамжуулан Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын нэгж, албан хаагчид хэвийн олгож байна. 2024.11.25-ны өдрийн байдлаар Дундын мэдээллийн сангаар дамжуулан улсын хэмжээнд нийт 56,186 газар эзэмших, ашиглах эрх улсын бүртгэлд бүртгэж улсын бүртгэлийн дугаар олгосон байна.</p> <p>УБЕГ-аас Монголын Нотариатчидын танхимын 273 нотариатчтай Мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах гэрээг байгуулсан. Төлбөрийн системийн хөгжүүлэлтийг Монголын Нотариатчидын танхимын зүгээс хийж дуусгахаар ажиллаж байна.</p> <p>Барьцааны гэрээний дуусгавар болгох үйлчилгээний мэдүүлгийг цахимаар хүлээн авч боловсруулах системээр 2024.10.31-ний өдрийн байдлаар өссөн дүнгээр нийт 4,884 мэдүүлэг хүлээн авч боловсруулсан байна. Уг систем хэрэглээнд нэвтэрснээр иргэн БАНК-МИК-УБЕГ-т биечлэн очдог байсан бол шат дамжлага багасаж БАНК-УБЕГ-т ханддаг болсон ач холбогдолтой юм.</p> <p>Тайлант хугацаанд нийт 17,906 нас барсны бүртгэл хөтлөгдсөн бөгөөд ЭМЯ-ны нас барсны санг үндэслэн нас барсны бүртгэлийг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд бүртгэх ажлыг 2024.04.16-ны өдөр эхлүүлж 2024.11.25-ны өдрийн байдлаар 5,751 иргэнийг ЭМЯ-ны нас барсны дундын санд бүртгэсэн байна.</p>	100
11	4.2.1. Төрийн бүх шатанд	1. Төрийн бүх шатанд байгаа	2021 - 2024	-	Төрийн бүх шатанд байгаа	Монгол Улсын Засгийн газрын 49 дугаар тогтоол “2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай”,	100

	байгаа авлигыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлж, авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлж, төр иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгоно.	авлигыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлж, авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлж, төр иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгоно.			авлигыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ	Монгол Улсын Их Хурлын 2023.06.30-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор батлагдсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, хөтөлбөрт тусгагдсан холбогдох арга хэмжээг УБЕГ-ын 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган ХЗДХСайдаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, видео, нийтлэл, зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлагыг байгууллагын 23 нэгж /Ерөнхий газар, Нийслэлийн улсын бүртгэлийн газар, хэлтсүүд, 21 аймгийн улсын бүртгэлийн хэлтэс/-ийн цахим болон пэйж хуудсаар дамжуулан мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэн, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.3-д заасны дагуу хуулийн этгээдийн улсын бүртгэлийн нээлттэй мэдээллийг www.opendata.burtgel.gov.mn сайтад байршуулж, нээлттэй харах боломжийг бүрдүүлсэн нь иргэд, олон нийтийн хяналт сайжирсан. Авилгийн эсрэг хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 1,065 албан хаагч 2023 оны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд шинэчлэн мэдүүлсэн. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-д заасны дагуу төсвийн орлого, түүний зарцуулалтыг байгууллагын цахим хуудсанд заасан хугацаанд байршуулан, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, байршуулсан мэдээллийг хуулийн хугацаа, үнэн, зөв байршуулсан эсэхэд сар бүр хяналт тавьж ажиллаж байна.	
12	4.2.5. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл,	3. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд өөрчлөлт оруулна. Төрийн албаны	2021 - 2024	-	Сургалт, сурталчилгааг явуулснаар үнэт зүйл, үндсэн зарчмаа хэрэгжүүлж, манлайллыг	Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээг шалгуур болгож байна. Ашиг сонирхлын зөрчлийн мэдээлэл, ёс зүйн зөрчлийн талаарх мэдээллийг утсаар, www.burtgel.gov.mn , contact@burtgel.gov.mn хаягаар	100

үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.	үнэт зүйл, зарчим, манлайллыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх талаар сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.			хангаснаар ёс зүйн зөрчил буурна.	гомдол, санал хүсэлтээр бичгээр хүлээн авч шийдвэрлэж байна. УБЕГ-ын “Ёс зүйн дэд хороо”-ний бүрэлдэхүүнийг УБЕГ-ын даргын 2024.08.09-ний өдрийн А/118 дугаар “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” тушаалын хавсралтаар шинэчлэн баталсан. Ёс зүйн дэд хороонд 2024.11.25-ны байдлаар 13 албан хаагчийн үйл ажиллагаанд гомдол гаргаснаас хуулийн тогтоомжийн дагуу арга хэмжээг авч, 13 дүгнэлтийг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн байна. Ёс зүйн дэд хороонд 2024 онд ирүүлсэн гомдлыг судлан нэгтгэн дүгнэвэл албан хаагчдын хүнд суртал, харилцаа хандлагатай холбоотой гомдол 90 хувь байна.	
Биелэлтийн дундаж үнэлгээ						91.4%
Оноо						4.57